

# ЕРТӨНЦИЙН ТАВАН МАХБОДЫН ТОГТОЛЦОО ХИЙГЭЭД ТАВАН ХОШУУ (Эртний ухаан судлал №3)

Н.Хавх, МУИС.НШУС.Философийн тэнхим. профессор.

**Түлхүүр үг:** Арга, билиг, махбод, зөрчил, нэгдэл, харилцан нөхцөлдүүлэх, үгүйсгэх, нөхөрлөлцөх, дайсагналцах,

Коммунистууд таван хошуугаар бэлэг тэмдгээ хийж ирсэн; Гэтэл Америкийн төрийн далбаан дээр өдий төдий таван хошуу байдаг; Хойд Солонгосын төрийн далбаан дээр мөн адил; Хятадын уламжлалт ухаанд ертөнцийн тогтолцооны арга, билгийн түгээмэл зүй тогтлыг таван хошуугаар тайлбарласан байдаг; Америк, Эртний Хятад улс бүгд таван хошууг бэлгэ тэмдэг болгосон; тэднийг коммунистууд мөн гэвээс бусдын хөх инээдийг хүргэхээр юм болно. Коммунистууд нь ч, коммунизмыг эсэргүүцэгчид нь ч; тэр эрт дээр үед ч, орчин үед ч таван хошууг тэглээ их шүтэн дээдлэн ирсэн нь ямар учиртай юм бол? Таван хошуу нь евклидийн хэмээх хавтгайн геометрийн ямар утга учиртай дүрс юм бол?

**Таван махбод, түүний арга билгийн утга.** Дорнын болон буддын гүн ухааны таван махбодын сургаалаар бол ертөнцийн бүх юмс ус, төмөр, шороо, гал, мод хэмээх махбодиос бүтэх агаад тэдгээр нь өөр хоорондоо төдийгүй, тус бүртээн арга, билгийн тогтолцоотой, харилцан бие биеэ үгүйсгэхийн хэрээр нөхцөлдүүлнэ, өөрөөр хэлбэл, нөхөр дайсны харилцаатай, нэг нь нөгөөгөө төрүүлэн гаргадаг ахиц шаттай, өөрөө хэлбэл эх хүүгийн харьцаатай аж.

Махбод хэмээх ойлголт нь өрнийн гүн ухаанд түгээмэл хэрэглэдэг бөгөөд ертөнцийг бий болгогч элемент, атом, атомын доторх эгэл жижиг хэсэг гэсэн утгаар бус, аливаа үзэгдэл юмст байх зөрчлийг агуулагч талууд, хөдөлгөгч хүч, энерги, мөн чанар гэсэн утгаар хэрэглэгдэнэ. Чухам ямар махбод нь ямар шинжтэй гэдгийг юмс хийгээд хүний шинжийн талаарх таван махбодын уламжлалт сургаалаас харж болно. Үүнд:

1. Гал махбод: юмс-хөдөлгөөнийг үүсгэх, хөдөлгөөнгүй юмыг сэргээх, дээш бадран тэмүүлэх; хүн-шийдэмгий, өөртөө итгэлтэй, зорьсондоо өөрийн хүчээр хүрнэ.

2. Шороон махбод: юмс-тогтворжуулах, хүндрүүлэх, суурь болох үүрэгтэй; хүн бусдаас хүчтэй, найдвартай, тогтвортой, хашир, аливаад бодитой хандана.

3. Төмөр махбод: юмс хөнгөн, шингэн, харьцангуй хувирамтгай, хөдөлгөөний эрч хүчтэй; хүн-эрс шийдэмгий, сэтгэлийн хөдөлгөөн ихтэй авч түүнийгээ жолоодно, удирдах ажилд сайн биш, бусдаас туслалцаа эс авна, уян хатан бус, хатуу чанга, гуйвалтгүй, зөрүүд, олон нөхөдтэй байж эс чадна, жаргал цэнгэлд дуртай.

4. Усан махбод: юмс-нам тогтуун эхлэх; хүн бусдын нөлөөнд оромтгой, гүйцэтгэх ажилд шаламгай, бусдын дэмээр амьдарна, олон нөхөдтэй байж эс чадна, жаргал цэнгэлд дуртай.

5. Модон махбод: юмс-тасралтгүй хөгжих, цэцэглэлт, мандах; хүн-өндөр ёс суртахуунтай, өөртөө итгэлтэй, олон талын сонирхолтой, бусдыг

өөртөө татна, өөрийн хүчийг хэт үнэлнэ, аливаа ажил нь урагшгүй байх нь олонтоо, нэг ажлын эцсийг үл үзэн нөгөөд орно.<sup>1</sup>

Энд голлон хүний зан чанараар жишээ аван судрын хэллэгийн хэлбэрээр таван махбодын тус бүрийн онцлогийг тодорхойлсон байна. Тогтвортой, хувьсамтгай хоёрын шүтэлцэх талаас нь сайтар анзаарваас эдгээр махбодууд нь хоёр хоёроор  $180^\circ$  эсрэг тэсрэг; Үүнд:

1. Усан махбод-хувьсамтгай нь тогтвортойгоос нэн ихээр давамгайлсан тогтолцоо буюу арга > билиг


2. Төмөр махбод-хувьсамтгай нь тогтвортойгоосоо давамгайлсан тогтолцоо буюу арга  $\geq$  билиг

3. Шороон махбод-хувьсамтгай тогтвортой хоёр шинжийн тэнцвэрт тогтолцоо буюу арга  $\equiv$  билиг

4. Гал махбод-тогтвортой нь хувьсамтгайгаас давамгайлсан тогтолцоо буюу арга  $\leq$  билиг

5. Модон махбод-тогтвортой нь хувьсамтгайгаас нэн ихээр давамгайлсан тогтолцоо буюу арга < билиг

Арга билгийн үүднээс бол хувьсамтгай нь хөгжлийн уг сурвалж болох зөрчлийг бий болгогч арга тал, тогтвортой нь түүний билгийн тал болно. Дээрх санааг, зүй тогтлыг арга билгийн график дээр харуулваас (зураг №1): Таван махбодын онолоор бол ертөнцийн бүх үзэгдэл юмс хөгжлийн уг сурвалж болох зөрчлийг бий болгогч эсрэг тэсрэг таван талуудад хуваагдана, энэ нь тогтвортой, хувьсамтгай шинжийн харьцаагаар нь тэднийг ангилж бүлэглэж тав хувааж болно гэсэн үг.



Зураг №1

Таван махбодын арга, билгийн тогтолцооны бүтэц, дарааллыг шүтэн барилдлагын түвшний хувьд амьдрал, практик дээр буулган дараах байдлаар ойлгоно. Үүнд:

1. Ус махбод (1) - сэтгэлийн хөдөлгөөнийг барих, жолоодох талаар нэн сул дорой хүмүүс.

2. Төмөр махбод (2) - сэтгэлийн хөдөлгөөнийг барих, жолоодох чадвар бүхий хүмүүс; гэхдээ нэлээдгүй тохиолдолд аливаад сэтгэлийн хөдөлгөөнөөр хандана.

3. Шороон махбод (3) - Сэтгэлийн хөдөлгөөн, оюун ухаан хоёр дээд зэргээр шүтэн барилдуулах замаар сэтгэлээ жолоодох өндөр чадвартай хүмүүс;

4. Гал махбод (4)- сэтгэлийн хөдөлгөөнөө барих чадвар сайтай хэдий ч, түүнийг хэтрүүлж сэтгэлийн хөдөлгөөнийг дарах эрмэлзэл тэмүүлэлтэй

5. Модон махбод (5)-Сэтгэлийн ямар ч хөдөлгөөнгүй хүмүүс; тэд оюун ухааныхаа хүч чадлаар, хүчээр сэтгэлээ дарна, түүнийг ямар ч хөдөлгөөнгүй, амьдралд өөрийн гэх үүрэггүй болгосон байх тохиолдол

<sup>1</sup>Д.Мөнх-Очир. Махбодийн гүн ухааны Монгол сургаал. УБ. 1997. номын хавтасны зураг хүмүүс;

Махбодууд хоёр хоёроор  $180^\circ$  эсрэг тэсрэг; үүнд: ус-мод; төмөр-гал; тэд зөрчлийг бий болгогч эсрэг, тэсрэг талууд; тухайн тогтолцоонд ус тэмцлийг, мод нэгдлийг, төмөр тэмцлийг, гал нэгдлийг түлхүү бий болгох үүрэгтэй.


Аливаа юмны бүрэлдэхүүн хэсгүүд харилцан бие биеэ нөхцөлдүүлэхийн хамт үгүйсгэх зүй тогтол хуулиар холбогдох таван бүлэгт хуваагдана. ангилагдана; энэ бол ертөнцийн оршин тогтнох түгээмэл хууль. Уралдаанд орж ирж байгаа морьд л гэхэд айргийн тавд шороон махбодтой цөөнх, түүний дараа төмөр махбодтой олонх, мөн гал махбодтой олонх, мөн түүний дараа модон махбодтой цөөнх барианд орж ирнэ. Шороон махбодтой бөгөөд айргийн тавд орж ирж буй нь хамгийн шилдэг сайн бөгөөд уяа сойлго нь таарсан морьдууд, модон махбодтой бөгөөд барианд сүүлдэж орж ирж байгаа нь харьцангуй сул дорой уяа сойлго нь таараагүй (баян ходоод лугаа адил), эсвэл хөгширч байгаа морьдууд; бусад нь шилдэг цөөнх, сул дорой цөөнх хоёрын хооронд байрлана.

Гэгээрлийн үүднээс бол: нэн сайн гэгээрсэн нь шороон махбодтой цөөнх буюу дээд төрөлтөн; нисванис буюу сэтгэлийн хөөрөл, хөдөлгөөнөөр амьдрагсад нь буюу усан махбодтой цөөнх; сэтгэлийн хөдөлгөөнийг дарамтлан амьдрагсад буюу модон махбодтой цөөнх; дээрх хоёр бүлэг хүмүүсийн хооронд гал, төмөр махбодтонгууд байрлана, тэд олонх байна. Геологийн шинжлэх ухаанд чулууны хатуулгийг 10 баллын шкал гэж байх агаад хамгийн хатуу бэх бат чанартай чулуу нь 10 балл байх агаад тийм чулууг алмаз гэнэ; алмаз шороон махбодтой байна гэсэн үг; хамгийн зөөлөн чулууг тальк гэх ба тальк 1 баллын хатуулагтай усан махбодтой, бусад чулууунууд нь алмаз, тальк хоёрын хооронд байрлана, тэд 2-9 баллын хатуулагтай, төмөр, гал, улмаар модон махбодтой минералууд болно.

Махбодуудыг байрлуулахдаа тэдгээрийн тус бүрийн онцлогийг тогтвортой хувьсамтгай талаас шүүн бодно; нэн тогтвортой, нэн хувьсамтгайг нь графикайн хоёр захад буюу нэн хувьсамтгай нь 1-д, нэн тогтвортойг нь 5-д; хувьсамтгай, тогтвортойг тэнцүүхэн шүтэлцүүлснийг нь 3-т байрлуулна; ингэж үзвээс 3-т шороо, 1-д ус, 5-д мод, 2-т төмөр, 4-т гал махбод тус тус байрласан. Ингэхлээр махбод бүр арга, билгийн тогтолцоотой байх агаад тэд бие биенээсээ тэрхүү арга, билгийн харьцааны хэр хэмжээгээр ялгагдана, зөрчлийг үүсгэнэ, хөгжлийн ахиц шат болно. График дахь муруйн цэг болгон математик, геометрийн утгатай байдгийн нэгэн адил цэг болгоныг арга, билгийн буюу махбодын холбогдолтой хэмээн үзэх учиртай юм; тийм болохоор аль ч махбод нь дотроо олон тооны махбод, усан махбод л гэхэд арга тал нь нэн ихээр давамгайлсан; арга, билиг хоёр нь тэнцүүхэн шүтэлцсэн, билиг талруугаа хэлбийж шүтэлцсэн гэх мэт байж болно; энэ санааг дараах зурагт (зураг№2) үзүүлэв.

Энд жагсаагдсан усан махбодын таван төрлийн төрөл бүр нь дахин тав, тэр тав нь тус бүртээн дахин тавд гэх мэтээр ертөнцийн юмс эцэс төгсгөлгүй хуваагдах зүй тогтолтой аж.

Европын гүн ухаанд материйг орон зайн хувьд хязгааргүй, эхлэлгүй, төгсгөлгүй хэмээн үзэх агаад ийм чигийн санааг буддын гүн ухаанд 5



Зураг№2

махбодын онолоор нарийвчлан боловсруулсан байдаг юм байна. Дорно дахины хөгжмийн онолд нэг эгшгийг л гэхэд дээрх арга ухаанаар 60 хүртэл хувааж, тэдгээр нь тав таваараа улиран дэвших, давтагдах зүй тогтолтой болохыг тайлбарладаг “Жаран эгшгийн зарлиг” хэмээх сургаал хүртэл байдаг байна.<sup>1</sup>

**Аливаа системийн оршин тогтнох зүй тогтол хийгээд таван махбодын сүлжээ**

Өрнийн гүн ухаанд системийн, структур-функционал онол, структурализм, функционализм хэмээх сургаал байх агаад

тэдгээр нь утга агуулгаараа ялгаатай хэдий ч зарчим нэгтэй. Ертөнцийн бүхий л үзэгдэл юмс өдий төдий элементүүдээс бүтэх агаад тэдгээр нь өөр хоорондоо тодорхой хууль зүй тогтлоор холбогдоно; нэг нь нөгөөгөөс шалтгаалан оршино; тэрхүү холбоог шалтгаан-үрийн холбоо гэнэ; тэдгээр элементүүдийн нэг нь нөгөөгийнхөө оршин тогтнох, өөрчлөгдөн хувирах шалтгаан нь болно; нөгөө нь түүний үр дагавар, үр дүн нь болно хэмээн үзнэ. Тийм үзлийг детерменизм гэж нэрлэдэг.

Бүх үзэгдэл юмс түүний бүрэлдэхүүн хэсэг болох элементүүд зөвхөн механикийн хуулиар холбогдоно гэх үзлийг механик детерменизм; ямар ч холбоо хамааралгүй байдаг гэх үзэл байх агаад тийм үзлийг индетерменизм гэнэ. Шалтгаан-үрийн холбооны тухай сургаалаар бол шалтгаан болох элемент нь тодорхойлох, үр дагавар нь тодорхойлогдох үүрэгтэй аж.

Гүн ухааны түүхэнд хожим сүүлд функциональ холбоо хэмээх ойлголт гарч ирсэн агаад функционализмаар бол системийг бүрдүүлэгч элементүүд нь өөр хоорондоо тэнцүүхэн хамааралтай холбоотой байна, тэнд тэр нь тодорхойлогч, энэ нь тодорхойлогдогч, нэг нь дагуулагч, нөгөө нь дагалдагч гэж байхгүй хэмээнэ.

Системийн онолын гол агуулгыг дор жагсааваас:

1. аливаа юмс элементүүдээс бүтнэ, түүнийг хэсгүүд гэнэ.
2. Элементүүд нь өөр хоорондоо шалтгаан-үр, эсвэл функциональ холбоогоор холбогдоно,
3. Элементүүд харилцан бие биедээ нөлөөлж, шинж нь харилцан шингэлцсэний үр дүнд синтезлэгдсэн шинж бий болно; түүнийг бүхэл системийн шинж ч гэж нэрлэнэ.
4. Бүхэл нь хэсгээ тодорхойлно, хэсгүүд нь шүтэн барилдаж бүхлийг бий болгоно.
5. Бүхэл, хэсэг хоёрын хамаарлыг үгүйсгэж, нэгийг нь нөгөөгөөс салгаваас механицизм, витализм хэмээх буруу үзэл, номлол бий болно;

Механицизм нь системийг түүний бүрэлдэхүүн хэсгүүд элементүүдээр нь механикаар хувааж болно; тэгээд элемент тус бүрт шинжилгээ хийж, тэдгээрийн шинжийг тогтоогоод түүнийг нэгтгэн систем бүхлийн шинжийг тогтооно гэх, витализм нь систем, түүний элементүүд нь өөр хоорондоо ямар ч холбоогүй, систем шинж, бүхэл гээд байгаа тэр шинжийг ертөнцийн эзэн лугаа гадны хүчин зүйл бий болгоно, тэрхүү шинжийг энтелехия хэмээнэ.

---

<sup>1</sup>Л.Эрдэнэчимэг. Монгол гүр дууны гүн эгшиглэнгийн увидас. УБ., 2001, 170-185 дахь тал


Системийн онолын дээр өгүүлсэн агуулга нь ерөнхийдөө зөв юм; гэхдээ элементүүдийг ангилсан бүлэг зүйл үгүй; тэгээд тэдгээр хэсэг бүлэг элементүүд нь өөр хоорондоо холбогдох холбоо хамаарал, зүй тогтол нэн бүрхэг, нэн ерөнхий, бодит байдалд буулгахын аргагүй. Таван махбодын онолоор бол ертөнцийн бүх үзэгдэл юмс нэг нэгэнгүй ус, төмөр, шороо, гал, мод гэсэн таван бүлэгт хуваагдан ангилагдана, тэр таван бүлэг элементүүд нь өөр хоорондоо нөхөрлөлцөх хийгээд дайсагналцах; эх хийгээд хүү боллоцох гэсэн зөрчлийг бий болгогч эсрэг тэсрэг талууд бүхий холбоогоор холбогдоно. Аливаа үзэгдэл юмсын оршин тогтнох өөрчлөгдөн хувирах, хөгжих уг сурвалж бол зөрчил; буддын гүн ухааны таван махбодын онолд тэрхүү зөрчлийг шороо хийгээд мод, шороо хийгээд төмөр, гал хийгээд төмөр, ус хийгээд гал, ус хийгээд ус, мод хийгээд шороо, мод хийгээд мод гэсэн хос махбодууд хийгээд шороо, төмөр хийгээд гал, төмөр хийгээд мод гэсэн хос махбодууд бий болгоно. Тэд нөхөрлөлцөх, дайсагналцах холбоотой. Мөн зөрчлийн ус хийгээд төмөр, төмөр хийгээд шороо, шороо хийгээд гал, гал хийгээд мод, мод хийгээд гал хэмээх талууд эх боллоцох; гал хийгээд мод, мод хийгээд гал, гал хийгээд шороо, шороо хийгээд төмөр, төмөр хийгээд ус, ус хийгээд мод гэсэн хос махбодууд хүү боллоцох холбоогоор холбогдоно. Ийнхүү системийн элементүүдийг буддын гүн ухаанд хөгжлийн уг сурвалж болох эсрэг тэсрэг талууд болох махбодид хуваан, тэдгээрийн хооронд эх, хүү боллоцох 10, нөхөр дайсан боллоцох 10, бүгд 20 холбоо бий хэмээн үзнэ; энэ бол зөрчлийн махбодууд хоорондын суурь буюу үндсэн харьцаа; махбодууд хоорондын шүтэн барилдлагын үр дүнд дээрх зөрчилт холбоо хязгааргүй шахуу задарна. Элементүүд өөр хоорондоо шүтэн барилдаж бий болгосон тэр шинжийг нь буддын гүн ухаанд хоосон чанар хэмээн нэрлэнэ; тэр нь системийн онолоор бус бүхэл, ерөнхий, системийн шинж аж. Өрнийн гүн ухаанд элементүүдийн шинжүүд синтезлэгдэх гэсэн ойлголтыг буддын гүн ухаанд шүтэн барилдлага, шүтэн барилдах хэмээн нэрлэдэг аж.

**Махбодууд нөхөрлөлцөх, дайсагналцах зүй тогтол хийгээд диалектикийн эсрэг тэсрэгийн нэгдэл. тэмшлийн хувль**

**Махбодууд нөхөрлөлцөх зүй тогтол** Судар номонд "төмөр модны, мод шорооны, шороо усны, ус галын, гал төмрийн

нөхөр; гал усны, ус шорооны, шороо модны, мод төмрийн, төмөр галын дайсан; мод галын, гал шорооны, шороо төмрийн, төмөр усны, ус модны хүү; ус төмрийн, төмөр шорооны, шороо галын, гал модны, мод усны эх" хэмээсэн байдаг.<sup>1</sup> (Зураг№3) Нөхөрлөлцөнө гэдэг нь нөхөр болж буй махбодын шинж нь нөгөө нөхөр болж буй махбоддоо шингэнэ; синтезлэгдэнэ; Махбод хоорондын нэгдэл бий болно гэсэн үг юм байна. Жишээ нь, арга нь давамгайлсан төмрийн шинж билиг нь нэн ихээр давамгайлсан модонд шингэнэ, модон махбодыг эрчимжүүлнэ; Билиг нь нэн ихээр давамгайлсан мод махбодын шинж арга билиг хоёрын тэнцвэрт тогтолцоог шороо махбодод шингэнэ; Тэнд шороон махбодын билгийн шинжийг ахиулах замаар шороон махбодын арга, билгийн тэнцвэрт тогтолцоо билиг талруу нь хэлбийлгэх алдагдуулах үүрэгтэй; шороо усны нөхөр болно гэдэг нь арга билгийн тэнцвэрт тогтолцоог шорооны шинж арга


<sup>1</sup>Д.Мөнх-Очир. Махбодийн гүн ухааны монгол сургаал. УБ. 1997. номын хавтасны зураг



Зураг №3

нь нэн ихээр давамгайлсан усанд шингэн тэнд усны арга талыг багасгаж түүний хувьсамтгай шинжийг нь зохих хэмжээгээр багасгах үүрэг гүйцэтгэнэ; ус галын нөхөр болно гэдэг нь билиг нь давамгайлсан галд арга нь нэн ихээр давамгайлсан усны шинж шингэн, галын арга талын шинжийг ахиулах замаар түүний хөдөлгөөнийг зохих хэмжээгээр эрчимжүүлэх үүрэгтэй байна гэсэн үг болой. Махбодуудын шинж нэг нь нөгөөдөө хичнээн чиг шингэлээ шингэлээ гэхэд тэр махбод хэвээрээ л байх учиртай аж; зүй нь гэхэд төмрийн шинж модонд хичнээн ч шингэсэн модон махбод мод чигээрээ буюу билиг нь нэн

ихээр давамгайлсан хэвээрээ байх; Модны шинж шороонд шингэлээ гэхэд шороо шороо чигээрээ байх, түүний билиг тал нь нэмэгдсэн гэхдээн арга билгийн тэнцвэрийн хүрээнд байх гэх мэтээр ойлгогдоно. Энэ бүхнийг арга билгийн квадратаар харуулваас (Зураг №4)



Зураг №4

Квадратын доод талын сумаар бол 1. Төмөр модны нөхөр, 2. мод шорооны нөхөр, 3. шороо усны нөхөр, 4. ус галын нөхөр, Бие биендээ шинж нь шингэлцээгүй байхад аливаа махбод дахь арга билгийн харьцаа 25:75 байх агаад нэгний нь шинж нөгөөд дээд зэргээр шингэснээр уг харьцаа 33,33:66,66-аас үл хэтэрнэ; өөрөөр хэлбэл төмрийн шинж модонд шингэснээр 1. модон махбодон дахь арга талын шинж 33,33-аас, билиг талын 66,66-аас үл хэтэрнэ гэсэн үг; энэ байдлаар модны шинж шороонд 2, шорооны шинж усанд 3, усны шинж галд 4 дээр харьцаагаар шингэнэ, махбодууд нөхөрлөлцөнө гэсэн үг. Нөхөрлөлцөнө гэдэг нь хоёр өөр махбодуудын шинж шингэж дундаас тэр хоёрын аль алинд нь байхгүй өөр чанарын махбод бий болно; зүйрлэвээс төмрийн шинж модонд шингэснээр төмрийн ч биш, модны ч биш тэр хоёрын шүтэн барилдлагаар өөр чанарын махбод бий болохын нэр. Таван махбодын онолоор махбодууд нь 5 удаагийн нөхөрлөлцлөөр хоёр хоёроороо шүтэн барилдаж, синтезлэгдэж, нэгдэн нийлсэн, өөр чанарын 4 янзын махбодыг, тэр нь бас хоёр хоёроор

синтезлэгдэж, 2 янзын махбодот, тэр хоёр нь шүтэн барилдаж хамгийн дээд түвшний нэгдэл махбодыг бий болгоно. Өрнийн гүн ухааны диалектикийн эсрэг тэсрэг нэгдэл тэмцлийн хуулинд зөрчлийг бий болгогч эсрэг тэсрэг талууд нь харилцан бас бие биеэ үгүйсгэхийн хэрээр нөхцөлдүүлнэ, тэмцэлдэхийн хэрээр нэгдэлд хүрнэ гэсэн ойлголт бий; энэ бол эсрэг талуудын харилцааны хууль, зүй тогтол. Өрнийн гүн ухааны диалектикийн "Талууд харилцан бие биеэ нөхцөлдүүлэх" хэмээх ойлголт нь 5 махбодын онолын "махбодууд нөхөрлөлцөх" хэмээх ойлголттой утга агуулга нэг. Зөрчлийг бий болгогч удамшил хийгээд хувьсал, уламжлал хийгээд шинэчлэл, нэмэх хийгээд хасах цэнэг, төвөөс зугтах хийгээд ондооших, исэлдэх хүч, оюун ухаан хийгээд сэтгэл санаа, ижилсэх хийгээд ондооших, исэлдэх хийгээд ангижрах гэх мэт эсрэг тэсрэг талууд харилцан бие биеэ нөхцөлдүүлнэ гэдэг бол тэдгээр талуудын шинж нэг нь нөгөөдөө шингэлцэн ингэснээр тэдгээрийн дундаас системийн шинж буюу "бүхэл" бий болохыг хэлнэ. Зөрчлийг дээрх талуудын нэг нь тухайн тогтолцоондоо нэгдлийг, нөгөө нь тэмцлийг бий болгоно. Үүнийг махбодуудтай харьцуулан үзвээс: - төмөр нь тэмцлийг, мод нь нэгдлийг; шороо нь тэмцлийг; шороо нь нэгдлийг уг нь тэмцлийг; гал нь нэгдлийг, шороо нь тэмцлийг; тус тус бий болгох үүрэгтэй. Нэгдлийг бий болгох үүрэгтэй махбодууд нь тухайн тогтолцоогоо тогтвортой тэнцвэртэй байлгах хөгжлийг нь тухайн шатанд барьж тогтоох, бүрэлдэхүүн хэсгүүдийг нь шүтэн барилдуулах, нэгдүүлэх, хөгжил хөдөлгөөний зүг чигийг заах; тэмцлийг бий болгох махбодууд нь үүний яг эсрэг үүрэгтэй байдаг. Зөрчлийн тухай диалектикийн энэ хуульд зарчмын хувьд махбодын сургаалтай төстэй зүйл нэлээдгүй бий. Өрнийн хийгээд буддын гүн ухааны сургаалын аль алинд нь харилцан бие биеэ үгүйсгэхийн хирээр нөхцөлдүүлэгч эсрэг тэсрэг талуудын хоорондын харилцааг зөрчил, шүтэн барилдлага гэдэг байна; харин махбодын сургаалд энэ санааг махбод хоорондын нөхөр, дайсны харилцаагаар буюу махбодууд өөр хоорондоо нөхөрлөлцөх, дайсагналцах зүй тогтлоор гарган тайлбарладаг аж. Махбодууд нөхөрлөлцөнө гэдэг нэгнийх нь шинж нөгөөд шингэнэ; тэдгээрийн хооронд үгүйдээ гэхэд нэг талын нэгдэл бий болно гэсэн үг; махбодууд дайсагналцана гэдэг нэг нь нөгөөгөө үгүйсгэнэ, үгүйдээ гэхэд аль нэг талаас нь тэмцэл, дайсагналцал бий болно гэсэн үг. "Огторгуйн маань" хэмээх дээр дурдсан сударт "галын дайсан ус, усны дайсан шороо, шорооны дайсан мод, модны дайсан төмөр, төмрийн дайсан гал"<sup>1</sup> гэсэн байдаг. Харин энэ бүхнийг тонгоруулваас махбодууд өөр хоорондоо нөхөрлөлцөх ёс гарч ирнэ; үүнийг өгүүлвээс: гал төмрийн нөхөр, төмөр модны нөхөр, шороо усны нөхөр, ус галын нөхөр болно. Хэрэв Европын гүн ухаанд зөрчлийг бий болгогч эсрэг тэсрэг талууд нь харилцан бие биеэ үгүйсгэж, нөхцөлдүүлдэг бол махбодын сургаалиар махбодын нэг нь дайсагналцлыг бий болгодог. Гэхдээ энэ нь бас европын гүн ухаан дахь эсрэг тэсрэгийн нэгдэл, тэмцэл хоёрын гүйцэтгэдэг үүргийн агуулгатай нэн дөхөж очих юм, учир нь нөхөр болдог махбод нь тухайн тогтолцоонд нэгдлийн, дайсан болдог махбод нь тэмцлийн үүрэг гүйцэтгэх нь гарцаагүй зүйл; тухайлбал, "шороо модны дайсан, мод шорооны нөхөр" гэхэд л тухайн тогтолцоондоо шороо нь нэгдлийн, мод нь тэмцлийн үүрэг гүйцэтгэдэг, эхнийх нь тэрхүү тогтолцоогоо тэнцвэртэй байлгах, хоёр дахь нь түүний тэнцвэрийг алдагдуулах чигийн үүрэгтэй байна гэсэн үг. Махбодын онол, зөрчлийн тухай диалектикийн

хууль хоёрын хооронд ялгаатай зүйл бас их бий. Диалектикийн хуулинд системийг бүрдүүлэгч элементүүдийг холбогдох зүй тогтлоор ангилан, бүлэглэсэн юм үгүй; харилцан нөхцөлдүүлэх зүй тогтлыг энгийнээс нь нарийнд, доод шатнаас нь дээд түвшинд авч үзсэн зүйл тэнд бас үгүй, зөрчлийг бий болгогч нэгдлийн хийгээд тэмцлийн талууд нь тус тусдаа лавшруулсан задаргаа бол үгүй. Энэ хууль нь нэлээд ерөнхийлсөн агуулгатай, тийм болохоор түүнийг амьдрал практиктай холбоход, тодорхой үзэгдэл дээр буулгана бэрхшээл их. Тэгвэл 5 махбодын онол, дээр өгүүлснээр системийг бүрдүүлэгч элементүүдийг ус, төмөр, шороо, гал, мод гэсэн 5 бүлэгт хуваана; махбод бүр арга, билигт; арга билиг нь 64 болтлоо задарна; "харилцан нөхцөлдүүлсэн" буюу "нөхөрлөлцөх" харьцаа нь 5 бүлэгт, тэр нь шүтэн барилдаж хумигдах лавшрах хийгээд задрах тэлэх чиглэлээр өдий төдий ахиц шатуудтай байх жишээтэй.

**Махбодуудын дайсагналцах зүй тогтол** Эртний судар номонд гал усны дайсан, ус шорооны дайсан, шороо модны дайсан, мод төмрийн дайсан, төмөр галын дайсан хэмээсэн нь бий<sup>1</sup>. Тухайн тогтолцоонд гүйцэтгэх үүрэг үйлчлэх хүч, шинж чанарын хувьд нэг нь нөгөөгөө үгүйсгэж байгааг нэг махбод нөгөөдөө дайсагнаж байна хэмээх болов уу. Ингэхлээр, гал усыг, ус шороог, шороо модыг, мод төмрийг, төмөр галыг тус тус үгүйсгэнэ. Махбодын үгүйсгэл нь арга билгийн үгүйсгэл. Билиг нь давамгайлсан гал арга нь давамгайлсан усыг, арга нь давамгайлсан ус арга, билиг нь тэнцвэрт шороог, арга билиг нь тэнцвэрт шороо нь билиг давамгайлсан модыг, билиг нь давамгайлсан мод арга нь давамгайлсан төмрийг тус тус үгүйсгэнэ (Зураг№4-ийн квадратуудын дээд талын сумаар үгүйсгэл явагдана). Дайсагналцал буюу үгүйсгэл нь тухайн тогтолцооны хөгжил хөдөлгөөнийг эрчимжүүлэх үүрэгтэй байна. Төвөөс зугтах хүч нь нэн ихээр давамгайлсан буюу усан махбод нь төвөөс зугтах, тэмүүлэх хүчийг тэнцвэрт хүч болох шороон махбодыг, тэрхүү тэнцвэрт хүч болох шороон махбод нь тэмүүлэх хүч нь нэн ихээр давамгайлсан модон махбодтой хүчийг, тэрхүү хүч нь тэмүүлэх хүч нь давамгайлсан төмөр махбодтой хүчийг, тэр нь төвөөс татах хүч нь давамгайлсан гал махбодтой хүчийг, тэр нь төвөөс зугтах нь нэн ихээр давамгайлсан усан махбодтой хүчийг тус тус үгүйсгэнэ. Усан махбодтой гахай болон хулгана жилтэй хүн нь шороон махбодтой үхэр, хонь, нохой, луу жилтний үзэл бодол, үйл ажлыг үгүйсгэнэ; түүнтэй ам муруйна; тэдгээр жилтнүүд нь модон махбодтой бар, туулай жилтний үзэл бодол, үйл ажлыг үгүйсгэнэ; тэдгээр нь төмөр махбодтой бич, тахиа жилтнийг, тэдгээр жилтнүүд нь гал махбодтой могой, морь жилтнийг, тэдгээр нь усан махбодтой хулгана, гахай жилтнийг тус тус үгүйсгэж, тэдний үзэл бодол үйл ажиллагаатай сөргөлдөнө гэсэн үг. Энгийн үгээр хэлэхэд үгүйсгэж, дайсагнаж байгаа талаас нь үг сөрнө, шүүмжлэх хэрүүл гарна; үгүйсгэгдэж дайсагнуулж байгаа тал нь түүнийг ямар нэгэн хэмжээгээр хүлээн авахын нэр. Мод төмрийн шинжийг (Зураг№4-ийн 1) шороо модны шинжийг (Зураг№4-ийн 2), уг шорооны шинжийг (Зураг№4-ийн 3), гал усны шинжийг (Зураг№4-ийн 4) тус тус үгүйсгэн тэдгээрт зохистой хэмжээгээр (квадратын дээд талын сумын дагуу 2-3 хооронд) шингэнэ.

<sup>1</sup>Д.Мөнх-Очир. Махбодийн гүн ухааны монгол сургаал. УБ. 1997. номын хавтасны зураг



Өрнийн гүн ухааны диалектикийн эсрэг тэсрэгийн нэгдэл, тэмцлийн хууль дахь талууд харилцан бие биеэ үгүйсгэж байна гэдэг нь буддын гүн ухааны махбодууд нэг нь нөгөөтэйгээ дайсагналцах зүй тогтолтой агуулгын хувьд ойролцоо, гэхдээ бас нэлээд ялгаа бий. Өрнийн гүн ухаанд зөрчлийг бий болгогч талууд нь харилцан үгүйсгэнэ; буддын гүн ухаанд зөвхөн нэг талын үгүйсгэл, дайсагнал бий; тодруулваас эхний тохиолдол гал, ус хоёр харилцан бие биеэ үгүйсгэнэ, дайсагнана, хоёр дахь тохиолдолд гал усны дайсан, гал усыг дайсагнана, гал махбодтой хүн усан махбодтой хүнд дайсагнан хандана хэмээн тайлбарлагдана. Өрнийн гүн ухаанд зөрчлийг бий болгогч эсрэг тэсрэг хоёр талын хоорон дахь харилцан үгүйсгэлцэх зүй тогтлыг тайлбарлана, тэнд талуудын шинж чанараар ил ангилсан, бүлэглэсэн тэгэх тусмаа тэдгээрийн хоорон дахь үгүйсгэлийн тухай өгүүлсэн тайлбарласан юм огт үгүй; буддын гүн ухаанд болохоор эсрэг талуудын 5 махбодоор нэрлэсэн, тэгээд өөр хоорондоо арга билгийн тогтолцоогоор үгүйсгэгдсэн, дайсагналцсан зүй тогтлоор хэрхэн холбогдсоныг тайлбарладаг бүхэл бүтэн сургаал ном бий; тодруулваас эхний тохиолдолд зөрчлийг бий болгогч эсрэг тэсрэг талуудыг сайндаа л нэгдлийн, тэмцлийн гэж хоёр хуваагаад тэдгээр нь хэрхэн харилцан бие биеэ үгүйсгэдгийг тайлбарлана; хоёр дахь тохиолдолд зөрчлийг бий болгогч талуудыг нэн хувьсамтгай (ус); хувьсамтгай (төмөр); хувьсамтгай тогтвортой хоёрын тэнцвэрт шүтэлцээтэй (шороо); тогтвортой (гал), нэн тогтвортой (мод) гэж 5 хуваагаад энэхүү 5 бүлэг үзэгдэл юмс нэг нь нөгөөгөө үгүйсгэх зүй тогтлыг тайлбарлана.

**Нөхөрлөлцөх, дайсагналцах хоёрын шүтэн барилдлага** Буддын гүн ухааны хэлээр бол нөхөрлөлцөх нь билиг, дайсагналцах нь арга; махбодуудын нөхөрлөлцөл, дайсагналцалын шүтэн барилдлага нь арга билгийн шүтэлцээний хуулиар явагдана. Махбод бүхэн өөр хоёр махбодтой нөхөрлөлцөн дайсагналцах холбоогоор холбогдоно; тухайлбал, мод нь шороо, төмөр хоёртой; ус нь шороо, гал хоёртой; төмөр нь мод, гал хоёртой; шороо нь ус, мод хоёртой; гал нь төмөр, ус хоёртой тус тус нөхөрлөлцөнө, дайсагналцана. Гэхдээ нэг махбод талаасаа дайсагналцана, нөгөө махбод талаасаа нөхөрлөлцөнө, тодруулваас мод нь төмөртэй дайсагналцана; харин төмөр нь дайсагналцалыг хүлээн аван модтой нөхөрлөлцөнө, мод нь шороотой нөхөрлөлцөнө, харин шороо нь нөхөрлөлцлийг хүлээн аван модтой дайсагналцана; ус нь галтай нөхөрлөлцөнө, харин гал нь устай дайсагналцана. Энд дайсагналцал, нөхөрлөлцөл хоёр нэгэн зэрэг явагдана; төмөр нь галтай дайсагналцана, харин гал нь төмөртэй нөхөрлөлцөнө; гал нь устай дайсагналцана, харин ус нь галтай нөхөрлөлцөнө; махбодуудын нөхөрлөлцөх дайсагналцах нь нэг орон зайд, нэг цаг хугацаанд нэгэн зэрэг өнгөрнө. Хүмүүсийн хувьд гэхэд л нөхөр нь үхэр, луу, хонь, нохойн аль нэг жилтэй шороон махбодтой, эхнэр нь бар, туулайн аль нэгэн жилтэй модон махбодтой бол нөхөр нь эхнэртээн дайсагналцана, эхнэр нь нөхөртөөн нөхөрлөлцөнө; нөхөр "түймэр" тавина, эхнэр нь түүнийг унтраана, нөхөр "үг сөрж хэрүүл" үүсгэнэ, эхнэр уг хэрүүлийг зохицуулна; харин нөхөр нь шороо, эхнэр нь усан махбодтой бол эхнэр түймэр тавина, нөхөр түүнийг унтраана. Эхнэр нь хулгана, гахайн аль нэг жилтэй усан махбодтой, нөхөр нь могой, морины аль нэгэн жилтэй гал махбодтой бол нөхөр эхнэртээн дайсагналцана, "түймэр" тавина, эхнэр нь нөхөртөөн нөхөрлөлцөнө, түймрийг унтраана; гэх мэт. Дайсагналцах нөхөрлөлцөх нь арга, билгийн

тогтолцоотой, түүний дагуу өөр хоорондоо шүтэн барилдлагатай, Зураг№4 дэх арга билгийн квадратын 1-д доод талын сумаар төмөр модтой нөхөрлөлцөнө; дээд талын сумаар мод нь төмөртэй дайсагналцана; 2-т мөн доод талын сумаар мод шороотой нөхөрлөлцөнө; дээд талын сумаар шороо нь модтой дайсагналцана; 3-т мөн дээд талын сумаар ус нь шороотой дайсагналцана, доод талын сумаар шороо устай нөхөрлөлцөнө; 4-т дээд талын сумаар гал устай дайсагналцана, доод талын сумаар ус галтай нөхөрлөлцөнө; өөрөөр хэлбэл дээд талын сумаар махбодууд дайсагналцана, доод талын сумаар тэд нөхөрлөлцөнө. Ямар махбод нь ямартайгаа нөхөрлөлцөх, дайсагналцахыг Зураг№4-өөс хөөж олно.

Буддын гүн ухаанд аливаа юмс үзэгдлийн оршин тогтнох үндэс гэвэл:

Зөвхөн арга ч биш,

Зөвхөн билиг ч биш,

Арга билиг хоёулаа ч биш,

Арга билгийн шүтэн барилдлага хэмээх томъёолол бий;

үүнийг махбодууд дайсагналцах, нөхөрлөлцөх дээр буулган бодвоос аливаа юмс үзэгдлийн оршин тогтнох үндэс гэвэл:

Зөвхөн дайсагнал ч биш,

Зөвхөн нөхөрлөлцөл ч биш,

Дайсагнал, нөхөрлөлцөл хоёулаа ч биш,

Дайсагнал, нөхөрлөлцөл хоёрын шүтэн барилдлага

хэмээн томъёологдоно. Махбодууд зөвхөн дайсагналцах холбоогоор холбогдвоос тэр нь уг юмаа задрал бутралаар дуусгана; зөвхөн нөхөрлөлцлөөр дуусгаваас уг юмны хөгжил хөдөлгөөн зогсонги, царцангиар дуусна; Хэрэв дайсагнал, нөхөрлөлцөл хоёр шүтэлцэхгүйгээр зэрэгцэн явбаас юмсын нэг тал нь зогсонги царцангиар, үлдсэн нэг тал нь задрал бутралаар дуусна. Нөхөрлөлцөл, дайсагналцалын шүтэн барилдлага квадрат дээр бол 2, 3 хоёрын хооронд (Зураг№4) байж чадваас юмсын хөгжил хөдөлгөөн тэнцвэртэй атлаа эрч хүчтэй урагш ахин дэвшинэ.


Тухайн тогтолцооныхоо хөдөлгөөний дайсагналцал нь эрчимжүүлэх, нөхөрлөлцөх нь чиглүүлэх үүрэгтэй. Энэ нь гал махбодтой эхнэрийн зүгээс дайсагналцал гарснаар (Зураг №4-ийн 4) усан махбодтой нөхрийн үзэл бодол, сэтгэл санаа ямар нэгэн хэмжээгээр өөрчлөгдөнө; гэхдээ түүний бодолд эхнэрийн хэлсэн ярьсан нь зохистой хэмжээгээр тусгалаа олсон байна; усан махбодтой нөхрийн зүгээс нөхөрлөлцөх харьцаа гарснаар усан махбодтой эхнэрийн хэлэх ярих нь зохих хэмжээгээр зүг чигтэй болно, зүг чигтэй болсон дээрээ улам зүг чигтэй болно гэсэн үг. Хэрэв зөвхөн бие биетэйгээ дайсагналцаад байвал гэр бүлийн амьдрал амьдрал биш болж, зөвхөн нөхөрлөлцөөд байвал хөгжлийн уг сурвалж болох зөрчил үгүй, амьдрал ямар ч сонирхолгүй болон гэр бүлийн амьдрал зогсонги царцангиар дүүснэ.

**Махбодууд эх, хүү бололцох зүй тогтол хийгээд диалектикийн үгвйгсгэлийн үгвйгсгэлийн хvvль**

Эртний сударт ус төмрийн эх, төмөр шорооны эх, шороо галын эх, гал модны эх, мод усны эх; мод галын хүү, гал шорооны хүү, шороо төмрийн

хүү, төмөр усны хүү, ус модны хүү хэмээн хэлсэн байдаг (зураг №3-г эргэж харна уу). Махбодиуд хос хосоороо зөрчлийг бий болгогч талууд мөн юм бол түүнийг шийдвэрлэхийн хэрээр хөгжил нэг шатнаас илүү дээд шатанд ахин дэвших замаар, гэхдээ дараагийн шатанд дээрхийн нэгэн адил арга билгийн

тогтолцоотой боловч бас өөр махбодуудийн хооронд зөрчил бий болж тэр нь шийдвэрлэгдэхээр түүний дараагийн шатанд мөн өөр махбодууд зөрчлийг бий болгох мэтээр хөгжил өрнөнө; ингэхдээ өгсөх хийгээд уруудах, улирах хийгээд дэвших шатыг дамжина. (зураг №5)



1.-Усан махбодтой шат; арга нь билгээсээ нэн давамгайлна, сэргэлт.

2.-Төмөр махбодтой шат; арга нь билгээсээ давамгайлна, өсөлт.


3.-Шороон махбодтой шат; арга нь билигтээ шингэж шүтэлцэнэ, оргил.

4.-Гал махбодтой шат; билиг нь аргаасаа давамгайлна, ургуулалт.

5.-Махбодтой шат; уналт.

Хүнээр л гэхэд зураг № 5-ийн 1 нь хүүхэд ахуй нас (ус), 2 нь идэр залуу нас (төмөр),

3 нь эрийн цээнд хүрсэн нас (шороо) 4 нь ахицаг нас (гал), 5 нь хөгширсөн нас (мод). Аливаа юмны хөгжлийн ахиц шат, улиран дэвших замыг ийм зүй тогтлоор тайлбарлаж болно Зураг №5 дахь зүй тогтлыг махбодь тус бүрийг арга билигтэй нь, өсгөх уруудах шатыг улиран дэвших замтай нь, бас туйлшралтай нь дараах зургаар илүү тод илэрхийлж болно. (зураг№6)



Энд махбодиуд нь хөгжлийн ахиц шат буюу зураг№6 дахь утгаар ойлгогдоно; хөгжлийн муруй, босоо координатад шахагдан ойртохын хирээр задрал бутралын аюул нөмөрнө; гэвч энэ бүхэн нь билгийн талын эсэргүүцэлтэй (дайсагналтай) тулгарч, түүнээс болж уг муруй усны "эх" болох модон махбодын шатруу шилжиж тэнцвэрийг олно; уг муруй координатад ойртохын хэрээр хөгжилд зогсонги царцанги аюул нөмөрнө, түүний хэрээр аргын талаас эсэргүүцэлтэй тулгарч, түүний улмаас өөрийн "хүү" болох гал махбодын шатанд шилжинэ; тэр нь яваандаа өөрийн "хүү" болох шороо махбодын шатанд; тэр нь мөн яваандаа төмөр махбодийн шатанд шилжих, энэ бүхэн эргээд давтагдана, гэхдээ дотогшоо хучигдах спиралаар яван явсаар шороон махбодын дээд шатанд хүрч хөгжил өндөрлөнө.

Хөгжлийн энэхүү зүй тогтолыг модноос эхлэх тохиолдол бий. Хэрэв усан махбодын туйлшрал бий болж, уг махбодын билиг тал нь устаж зөвхөн


арга тал нь үлдвээс юмсын хөгжил задрал бутралаар дуусна (зураг №6-ын б), усан махбод ч арга, билгийн тогтолцоогүй болж, махбод буюу юмсын оршин тогтнох нэг гол эх булаг байхаа болино (зураг №6-ын 7-оор тэмдэглэгдсэн тохиолдол бол билгийн туйлшрал, юмсын хөгжил зогсонгиор дуусна, мод нь махбод байхаа болино). Махбодууд эх бололцох хүү бололцох зүй тогтол ийм байх болой. Одоо эх бололцох, хүү бололцох зүй тогтол, диалектикийн үгүйсгэлийн хуультай холбоотой эсэх, холбоотой бол юугаараа ижил төстэй, юугаараа ялгаатай болохыг авч үзье.

Диалектикийн үгүйсгэлийн үгүйсгэлийн хууль аливаа юмсын хөгжлийн өнгөрсөн, одоо, ирээдүй диалектик үгүйсгэлээр тайлбарлагдана. Хөгжлийн өмнөх шатнаас аль илүү дэвшилтэт бүхэн нь уламжлагдах, хөгжилд үүргээ гүйцэтгэж дууссан бүхэн нь үгүйсгэгдэн, орхигдон гээгдэн үүргээ гүйцэтгэж дууссан бүхэн нь хөгжлийн дараагийн шатанд шинэ шинж бий болох, тэр нь уламжлагдан ирсэн дэвшилттэй шинжтэй зөрчилдөн тэмцэлдэж, тэр хоёр нь өөр хоорондоо зөрчилдөн тэмцэлдэх замаар шүтэн барилдаж, нэгдэхэд хүрэх замаар өрнөх зүй тогтолтой аж. Хөгжлийн өмнөх шатнаас уламжлагдан ирсэн дэвшилттэй шинжийг хуучин шинж, дараагийн шинээр бий болсныг шинэ шинж гэнэ. Энэ бол диалектикийн үгүйсгэл; үүнээс гадна метафизик үгүйсгэл гэж байх агаад тэр нь хөгжлийн өмнөх шатанд байх шинжийг бүхэлд нь үгүйсгэх үгүйсгэл аж.

Эхний үгүйсгэлээр бий болсон шинж хоёр дахь удаагаа үгүйсгэгдэхэд аливаа юмсын хөгжил дээд оргил шатандаа хүрч очно; гэхдээ энэ бүхэн зөрчлийг бий болгогч эсрэг тэсрэг талууд болох арга, билиг хоёр харилцан байраа солилцох замаар, буюу эхний шатанд арга улирч, билиг нь давшиж, дараагийн шатанд улирсан нь дэвшиж, дэвшсэн нь улирч гэх мэтээр спиралиар явагдана. Энэ бол хөгжлийн диалектик зам. Метафизик сэтгэлгээгээр бол хөгжил эсвэл тойргоор (билиг нь дагнасан тохиолдолд), эсвэл шулуун шугамаар (арга нь дагнасан тохиолдолд) явагдана. Диалектикийн үгүйсгэл үгүйсгэлийн хуулийн гол агуулга ийм байна. Буддын гүн ухааны 5-н махбодын сургаалд дээрх үзэл санаа бараг тэр чигээрээ бий. Үгүйсгэлийн хуулийн шинэ, хуучин хоёр шинж нь буддын гүн ухаанд шинийг арга, хуучныг нь билиг гэнэ; махбодын онолд болохоор эх бололцох талаасаа бол өмнөх шатны махбодыг хуучин, дараагийн шатны махбодыг шинэ гэнэ. Тодруулваас;  $ус = a > б$ ,  $төмөр = a$   $б$ ,  $шороо = a$   $б$ ,  $гал = a > б$ ,  $мод = a < б$ ; хүү бололцох талаасаа бол дээрхийн эсрэг; шинэ буюу арга, хуучин буюу билиг хоёр зөрчилдсөөр нэгдэх буюу хоосон чанар бий болно. Өрнийн гүн ухаанд үеэ өнгөрүүлсэн шинж нь орхигдож, үгүйсгэгдэнэ; 5 махбодын онол болохоор хөгжил уснаас төмөрт, төмрөөс шороонд шилжихэд илүүдэл арга буюу үеэ өнгөрүүлсэн нь багасна, түүний оронд билиг эзлэх жин нэмэгдэнэ; шорооноос галд, галаас модонд шилжихэд дээрх үйл явц лавширна; үгүйсгэлийн хуульд эхний үгүйсгэлээр бий болсон шинж хоёр дахь удаагаа үгүйсгэгдэхэд хөгжлийн оргил шатанд хүрнэ -5 махбодын ус үгүйсгэгдэж төмөр болно, төмөр үгүйсгэгдэж түүний тал билиг нь дэвшиж, арга нь багассан шороо үүснэ; үүний дараа гал үгүйсгэгдэж мод болно, мод үгүйсгэгдэн бас арга дэвшиж, билиг нь улиран шорооны шороо болж, энэ нь шүтэн барилдлагын дээд түвшин, дээд нэгдэл; үүний дараа гал үгүйсгэгдэж мод болно, мод үгүйсгэгдэн бас арга дэвшсэн, билиг нь улирсан шороо; түүний дараа энэ хоёр шороо өөр хоорондоо шүтэн барилдан бүүр дээдийн дээд түвшний нэгдэл, хоосон чанарыг бий болгоно.

**Таван хошуу хийгээд махбодууд нөхөрлөлцөх дайсагналцах эх хүү бололцох зүй тогтол**

өлзийгөөр загварчлагддаг тухай дээр өгүүлсэн (зургийг эргэж харна уу). Уг зургийг загварчилсан зүй тогтол буюу махбодын шинж, тэдгээрийн нөхөр хийгээд дайсан, эх хийгээд хүүгийн харилцаа, улмаар лавшруулан бодвоос, шинж нь харилцан бие биедээ шингэх (аль махбодын шинж нь аль махбоддоо шингэх) хөгжлийн ахиц шат, тэрхүү шатан дахь махбод хоорондын зөрчил, нэг үгээр хэлэхэд ертөнцийн тогтолцооны загвар, түүний оршин тогтнох, ахин дэвших зүй тогтол таван хошуунд тэр чигээрээ шингэн багталцсан нь нэн сонирхолтой (зураг№7).



Зураг№7

Махбодууд нөхөрлөлцөх дайсагналцах эх, хүү бололцох зүй тогтол нь эртний сударт зураг №3-д дүрсэлсэн махбодын шүтэлцээний

1)-шулуун сумны дагуу дайсагналцана; шороо модны дайсан, мод төмрийн дайсан, төмөр галын дайсан, гал усны дайсан, ус шорооны дайсан хэмээн уншигдана;

2)- шулуун сумны эсрэгээр нөхөрлөлцөнө; мод шорооны нөхөр, шороо усны нөхөр, ус галын нөхөр, гал төмрийн нөхөр, төмөр модны нөхөр, мод шорооны нөхөр бололцоно;

3)-нар зөв эргэх сумаар эх бололцоно; ус төмрийн эх, төмөр шорооны эх, шороо галын эх, гал модны эх, мод усны эх болох аж;

4)-нар буруу эргэх сумаар хүү бололцоно; мод галын хүү, гал шорооны хүү, шороо төмрийн хүү, төмөр усны хүү, ус модны хүү болох аж;


5)-нэг шугаман дээрх дагуу сум эсрэг сум хоёр махбодууд нөхөрлөл, дайсагналцал хоёр шүтэн барилдах, улмаар шинж нь бие биедээ шингэх зүй тогтолыг илэрхийлнэ;

6)-нар зөв, буруу эргэх сум нийлээд хөгжлийн ахиц шат, тэдгээр шатны залгамж холбоо, шинэ хуучин хоёрын шүтэлцээг тус тус тайлбарлана. Энэ бүхэн нь дорно дахины хүмүүс, түүний дотроос дорно дахины суут сэтгэгчид аливаагийн олон талыг дээд зэргээр шүтэн барилдуулах, агуу их нэн гүнзгий санааг хамгийн энгийн хэлбэрээр илэрхийлэн харуулах, тайлбарлах билиг хэмээх оюун ухаан, сэтгэн бодох өндөр чадвартай байсны илрэл, үр дүн биз. Тэгээд ч Дорно дахинд таван хошууг эв нэгдэл, бат найрамдал, ертөнцийн зөв тогтолцооны бэлгэ тэмдэг болгон дээдэлж байсны цаана гүн гүнзгий утга, агуулга бий аж.


**Таван хошуу хийгээд пирамид кубын хууль**

Махбод болгон дор дороо нэг нэг пирамид, пирамидууд дор дороо таван хошууны нэг нэг хошуу болно; (зураг №8)

Пирамидууд сумын дагуу дайсагналцана, эсрэг сумаар нөхөрлөлцөнө; нар зөв эргэх сумаар эх бололцоно, нар буруу эргэх сумаар хүү бололцоно. Пирамид хоорондын шүтэн барилдлага кубын хуулиар




Зураг№8




Зураг№9

явагдана. (Зураг№9) Таван хошууны ус нь кубын дээд талын "таг"(2) пирамид; төмөр нь кубын "ёроол" пирамид (4); шороо нь кубын баруун, мөн зүүн тал пирамид (5), (6); гол пирамид нь кубын "нүүр" (1), мод нь кубын "ар" (3) тус тус болно. Таван хошуу бүрд байрлах арга билгийн квадрат нь 5 янзын пирамидын нэгээр нь буюу кубын нүүр болох пирамидаар төлөөлүүлж харуулав. (Зураг№10); зураг№11-д кубын задаргааг пирамидаар, пирамидаа хавтгайд буулган квадратаар харуулав.Таван хошууны таван үзүүрт байрлах квадратууд нь угтаан кубын 5 тал, 5,6 дахь талууд буюу шороон махбодтой талууд нь талуудынхаа шүтэн барилдлагыг илэрхийлнэ, үүнийг яаж ойлгох вэ гэхлээр мод нь (3) төмөртэй (4) төмөр нь галтай (1), гал нь устай (2) дайсагналцаад шороон махбодтой пирамидыг (6) бий болгоно; энэ бол таван хошууны дээд тал буюу арга нь дэвшиж, билиг нь улирсан пирамид, дээд нэгдэл шүтэн барилдлагын дээд түвшин; бас нөхрийн зүй тогтлоороо бол ус (2) галтай (1), гал төмөртэй (4) төмөр модтой (3), мод шороотой (5) шүтэн барилдаж; кубын баруун талын пирамид

(5), зүүн талын пирамидтай шүтэн барилдаж кубын голд нэгдэн нийлнэ, уулзан золгоно; энэ нь мэнгээр бол 5 шар мэнгэ. Ийнхүү таван хошуун ертөнцийн тогтолцооны хамгийн гүний бөгөөд түгээмэл загвар болох кубын хуулийн нэгэн хувилбар аж. Олон тооны улсууд төрийнхээ далбаан дээр 5 хошуу байрлуулж байгаа нь, тухайн үндэстэн дотроо ч, дэлхийн улс үндэстэн бүхэлдээ ч ертөнцийн оршин тогтнох хамгийн гүн гүнзгий зүй тогтлоор холбогдож өөр хоорондоо дээд зэргээр нэгдэл нягтралтай байхыг бэлгэдсэн аж.




Зураг №10



(a)  
Зураг №11

**Таван хошуугаар оны махбодыг олох арга** Буддын гүн ухааны таван махбодын онол ертөнцийн хамгийн гүний бөгөөд түгээмэл зүй тогтолыг тайлбарладгын хувьд зурхайн ухааны арга болно. Энд таван хошуугаар жилийн махбод хэрхэн тогтоохыг авч үзье. Хүү бололцох зүй тогтлоор энэ болоод дараагийн жилүүдийн, эх бололцох зүй тогтлоор өнгөрсөн жилүүдийн махбодыг тогтоож гэхдээ махбод бүрт хоёр хоёр жил багтана. (зураг №12, хүснэгт №1,2)




Зураг №12  
(Хүү бололцох зүй тогтол)

Дээрх он дарааллыг хүснэгтэнд оруулваас уншихад, ашиглахад тохиромжтой.

Хүснэгт№1

	бич	тахиа	нохой	гахай	хулгана	үхэр	бар	туулай	луу	могой	морь	хонь
мод	2004	2005	2052	2053	2042	2043	2032	2033			2014	2015
гал	2016	2017	2006	2007	2054	2055	2044	2045	2034	2035	2024	2025
шороо	2026	2027	2018	2019	2008	2009	2056	2057	2046	2047	2026	2037
төмөр	2038	2039	2028	2029	2020	2021	2010	2011	2058	2059	2048	2049
ус	2050	2051	2040	2041	2030	2031	2022	2023	2012	2013	2060	2061

Хүснэгтэнд бичлэгээ хэдэн оноос эхлэхээр байнав, махбодын харгалзах нүдэнд тэр болон дараагийн оныг, ер нь нэг махбодын харгалзах нүдэнд оныг бичнэ (хүснэгтэнд харлуулж харуулав), дараа дараагийн оныг хоёр хоёроор нь диагналдаж бичнэ, босоо шугаманд бичигдсэн жил, махбодын нүд дуусмагц (тухайн тохиолдолд могой, усаар дуусаж байна) залгуулаад модон махбод, морь жилд оноо бичнэ (тухайн тохиолдолд жилээ морь, хониос -2014, 2015, махбодоо галаас эхэлнэ -2016, 2017 гэх мэт) хүснэгтийг дуусмагц нэг нүдэнд хэд хэдэн оныг багтааж бичнэ(2014, 2005, 2062, 2063) үүний тулд хүснэгтийн нүд томхон хийх хэрэгтэй байдаг.



Зураг№13  
(Эх бололцох зүй тогтол)

Энэхүү он дарааллыг хүснэгтэд оруулваас хөтлөхөд, ашиглахад тохиромжтой. онуудыг хүснэгтэнд бичих нь, дээрхийн нэг адил зарчимтай; тухайн тохиолдолд 2004, 2005 оноос буюу модон мич, тахиа жилээс эхлэж; дараагийн нь махбод ус жил нь хонь, морь, тэр нүдэнд оноо үргэлжлүүлнэ



	бич	тахиа	нохой	гахай	хулган	үхэр	бар	туулай	луу	могой	морь	хонь
мод	2004 1944	2006 1945	1994	1995	1984	1985	1974	1975	1964	1965	1954	1955
гал	1956	1957	1946	1947	1996	1997	1986	1987	1976	1977	1966	1967
шорсо	1968	1969	1958	1959	1948	1949	1998	1999	1988	1989	1978	1979
төмөр	1960	1961	1970	1971	1960	1961	1960	1951	2000	2001	1990	1991
ус	1992	1993	1982	1983	1972	1973	1962	1963	1952	1953	2002	2003

2003, 2002 гэж бичнэ. Түүний дараа махбодоо ахиулж могой луу гэх мэтээр хүснэгтийг үргэлжлүүлж болно. Дээрхээс гадна 5 хошуу хүмүүс, эхнэр нөхөр хоёр ээлтэй, ээлгүй зэргийг зурж гаргах үндэс болох болов уу гэж бодогдоно. Нөхөр нь ус махбодтой, эхнэр нь төмөр махбодтой болвоос нөхөр нь эхнэрээ эхийн хайраар, эхнэр нь нөхрөө хүүгээ хайрлах хайраар гэх мэтээр хайрлана гэсэн үг. Эх хүү бололцох зүй тогтлоор холбогдсон хоёр хүн нэг нь нөгөөтэйгээ ээлтэй жилтэй байхаар; тэгээд ч эхнэр нь нөхрөөс 5 дүү эсвэл 5 ах байваас их сайн гэдэг. Нөхөр дайсан харьцаатай байх тохиолдол ээлгүй, ялгаагүй гэж яригдах байх. Таван махбодын онолоор аливаа үзэгдэл юмсыг 5 бүлэг болгон ангилан тайлбарлах бүрэн бололцоотой төдийгүй анатомын онолын агуулгыг ч баяжуулан тайлбарлаж болох юм. Уран зохиолч хүн зохиолын баатруудаа 5 махбодын онолоор бүтээж ч болохоор төсөөлөгдөнө, ингэхийн тулд баатруудаа 5 бүлэгт хуваана, 12 жилийн аль нэггүй; түүнд харгалзах махбодгүй хүн гэж байхгүй; тэр 5 бүлэг, эсвэл 5 баатрууд хүссэн ч хүсээгүй махбодоо дагасан өөр өөрийн шинжтэй, хүссэн ч хүсээгүй махбод хоорондын нөхөрлөлцөх, дайсагналцах; эх, хүү бололцох харьцаатай; түүний дагуу баатруудынхаа уран сайхны дүрийг гаргаж тавьбаас тэр нь буддын гүн ухаанд суурилсан агуулгатай зохиол болохоор төсөөлөгдөнө.

**Таван хошуугаар мэнгэ олох арга\*** 12 жилийг дагасан хүний шинж төрх, амьдралын хэмнэл зэргийг зааж зурах, оноон тодорхойлдгийн хувьд жил, мэнгэ хоёр нэг чигийнх: мэнгэний шинж нь жилийнхээ шинжийн нэлээд хэмжээгээр зангидсан, төвлөрүүлсэн шинж байхаар төсөөлөгдөнө. Хүний биохэмнэл нь оюун ухаан, сэтгэл санаа, бие хэмээх амьдралыг авч явагч гурван чигийн хүчин зүйлийн улиран дэвших зүй тогтолтой. Энэ гурван ойртолт, нэгдлийг "мэнгэ" гээд байгаа юм болов уу гэж бодлоо. Жил орно гэдэг нь энэ гурван чигийн хүчин зүйлийн салалт холдолт яриа байхгүй мөн; Тэрээр хүмүүсийн ажил амьдралд учрах бэрхшээл зовлонгийн дээд цэг. Харин мэнгэ голлоно гэсэн ойлголт нь биохэмнэлийн нэгдэлтэй байх үе нь дуусч, тэмцэлтэй, задралтай байх үед орлоо гэсэн утга санааг илэрхийлэх мэт санагдана. Зүй нь гэхэд хоёр хар мэнгэтэй бичин жилтэй хүний хувьд бол "Арга билиг төгөлдөр" шинж дээд цэгтээн хүрсэн, тэгээд

\*"Философи, шашин судлал" сэтгүүлийн 2007№37-ийн 7-14 дэх талд хүний мэнгийг таван хошуугаар бодох аргыг тайлбарласан бөгөөд энд энэхүү тайлбарыг давтан хийв.

буурах, муудах шатандаа орлоо гэж ойлгогдлоо. Мэнгэ тус бүр өөрийн жил (Хүснэгт №3) түүнийг дагасан махбодтой арга, билигтэй.

Хүснэгт№3\*

Мэнгэ	Жил			
9 улаан	Үхэр	Нохой	Хонь	Луу
8 цагаан	Бар	Гахай	Бич	Могой
7 улаан	Туулай	Хулгана	Тахиа	Морь
6 цагаан	Луу	Үхэр	Нохой	Хонь
5 шар	Могой	Бар	Гахай	Бич
4 ногоон	Морь	Туулай	Хулгана	Тахиа
3 хөх	Хонь	Луу	Үхэр	Нохой
2 хар	Бич	Могой	Бар	Гахай
1цагаан	Тахиа	Морь	Туулай	Хулгана

Хүснэгт№4<sup>1</sup>


9	8	7	6	5	4	3	2	1
улаан	цагаан	улаан	цагаан	шар	ногоон	хөх	хар	цагаан
1901	1902	1903	1904	1905	1906	1907	1908	1909
1910	1911	1912	1913	1914	1915	1916	1917	1918
1919	1920	1921	1922	1923	1924	1925	1926	1927
1928	1929	1930	1931	1932	1933	1934	1935	1936
1937	1938	1939	1940	1941	1942	1943	1944	1945
1946	1947	1948	1949	1950	1951	1952	1953	1954
1955	1956	1957	1958	1959	1960	1961	1962	1963
1964	1965	1966	1967	1968	1969	1970	1971	1972
1973	1974	1975	1976	1977	1978	1979	1980	1981
1982	1983	1984	1985	1986	1987	1988	1989	1990
1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999
2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008

Энэ хүснэгтээс амьдралын мэнгэ, жилийн янз бүрийн биохэмнэл, давтамж улиран дэвших зүй тогтлыг тооцоолон гаргаж болно. Мэнгэ тус бүрт харгалзах дөрөв дөрвөн жил нь цаг хугацааны хувьд өнгөрсөн рүүгээ чиг, ирээдүй рүүгээ чиг эцэс төгсгөлгүй давтагдана. Тэгэхдээ таван махбодын зүй тогтлоор энэ бүхэн явагдана. Хүний мэнгэний махбодыг жилийн ерөнхий махбодоос хөөж гаргана. Мичин жилтэй хүний мэнгэний оны давтамжийг түүний өөрийн нь ерөнхий махбод болох төмрөөс хөөж энд гаргана. (Зураг№14) Мичин жилтэн 2 хар, 5 шар, 8 цагаан, 12 жилийн үлдсэн бусад дээр нь мэнгэний давамжийг дээрх аргаар гаргаж болно. Харин мэнгэний бүтэц нь өөр өөр байна. 1901 он үхэр, 1902 он бар, 1903 туулай гэх мэтээр

<sup>1</sup>Монголын зурхайн хүн судлал. УБ. 1992, 22 дахь тал

\*Энэхүү хүснэгтийг хүснэгт №3-аас хэеж гаргав. Үүний тулд оны дарааллаа 12 жилийн тоололд оруулж

дөрөв дахин давтуулна;  
 Үхэр жилтэн л гэхэд 9 улаан, 6 цагаан, 3 хөх; бар жилтэн 8 цагаан, 5 шар, 2 хар; туулай жилтэн 7 улаан, 4 ногоон, 1 цагаан; луу жилтэн 6 цагаан, 3 хөх, 9 улаан; могой жилтэн 5 шар, 2 хар, 8 цагаан; морь жилтэн 4 ногоон, 1 цагаан, 7 улаан гэх мэтээр жилтэн бүр мэнгэний бүтцийн хувьд өөр өөр байна. Мэнгэнд урт, богино хугацааны өдий, төдий давтамж бий. Нэг махбодтой мэнгэнээс нөгөөд шилжихэд 12 жилийн тухайлбал шороон махбодтой хоёр хар мэнгэнээс, (1908 он), төмөр махбодтой 8 цагаан мэнгэнд (1920), түүнээс дараачийнхад, түүнээс дараачийнхад шилжихэд арван хоёр, арван хоёр жил болно. Нэг мэнгэ дахин давтагдахад 60 жил, тухайлбал 1944 оны төмөр махбодтой 2 хар мэнгэ 36 жилийн дараа буюу 1980 онд, тэр нь 2016 онд, тэр нь 2052 онд гэх мэтээр давтагдана гэсэн үг.



Зураг №14  
 (Мичин жилтний мэнгэний давтамж)

Мэнгэ дотрох жил нэг нь нөгөөгөөр солигдоход 9 жилийн, тухайн тэр мэнгэ 36 жилд дахин давтагдах зүй тогтолтой. Энэ нь юу гэсэн үг вэ гэхээр үхэр жилийн 9 улаан мэнгэ нохой жилийнхэд, тэр нь хонь жилийнхэд, тэр нь луу жилийнхэд, тус бүрт 9, бүгд 36 жил болно гэсэн үг. Махбодууд дор дороо арга, билгийн тогтолцоотой байдаг болохоор мэнгэ нь ч адил байх учиртай.

**Ашигласан материал**

1. Д.Мөнх-Очир. Махбодийн гүн ухааны Монгол сургаал. УБ. 1997.
2. Монголын зурхайн хүн судлал. УБ. 1990
3. М.И.Беляев. Милогия. 1999-2001, Вейбсайт. [www.yandex.ru](http://www.yandex.ru). Belyaev m. I. Гармония Ян и инь.
4. Л.Эрдэнэчимэг. Монгол гүр дууны гүн эгшиглэнгийн увидас. УБ., 2001,